



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/652

Есөнбулаг

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 42 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Төрийн аудитын газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн Говь-Алтай аймгийн салбар, Тогтвортой амьжиргаа-3 төсөл зэрэг байгууллагуудын хамтран зохион байгуулж байгаа Санхүү, бүртгэлийн ажилтнуудын ур чадварын уралдаан, нэгдсэн сургалт зөвлөгөөний үйл ажиллагаанд 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Санхүү, бүртгэлийн ажилтнуудын ур чадварын уралдаан, нэгдсэн сургалт зөвлөгөөнийг зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийн тайлангаа аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн Говь-Алтай аймгийн салбарын дарга (Б.Мөнхболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:\Documents\ ZD A-4 doc

0201001336

